

Хууль зүйн сайдын 2016. оны  
...А/204.. дугаар тушаалаар батлав



МОНГОЛ УЛС  
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ  
000136274

2017.01.23

/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011650102

/ Улсын бүртгэлийн дугаар /

6143768

/ Регистрийн дугаар /

Ган ресурс

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм

/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр

/ шийдвэрийн нэр /

01

/ дугаар /

2017.01.18

/ он, сар, өдөр /

7210

/ код /

Геологийн суурь судалгаа хийх

/ Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

8299

Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх

/ код /

/ Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй

/ хугацаа /

1

/ гишүүдийн тоо /

20.0

/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Баянзүрх, 5-р хороо, монел 16, 321а тоот, Утас1: 99999987, Утас2: , Факс:

/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /



Оюуны өмч, улсын бүртгэлийн  
ерөнхий газар Хуулийн этгээдийн  
бүртгэлийн газар  
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Баттөр овогтой Хүрэлбаатар-г Захирал-р томилсныг бүртгэв.	2017.01.23	Д.Чулуунтуяа
1	Хувь нийлүүлэгчээс 2 нэмэгдэж үүсгэн байгуулагчийн тоо нийт 3 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2018.04.30	С.Мөнхсанчир
2	Хувь нийлүүлэгчээс 1 нэмэгдэж, 1 хасагдаж үүсгэн байгуулагчийн тоо нийт 3 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2018.11.19	Ж.Оюумаа
3	Цогбаяр овогтой Амархүү -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2018.11.19	Ж.Оюумаа
4	9700 Гэрээгээр өрөмдлөг хийх эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2019.06.21	В.Хандсүрэн
5	7010 Геофизикийн суурь судалгаа хийх эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2019.06.21	В.Хандсүрэн



Энэхүү гэрчилгээ хуурамчаар үйлсэн эг бэлдэ Монгол Улсын хуулийн дагуу харуулааг хүлээг ага  
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүүшиггүй.



**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН  
ХАЙГУУЛ СУДАЛГАА, НӨӨЦ ТОГТООХ  
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2019 оны 07 дугаар  
сарын 19-ны өдөр

Дугаар АГГ-19/132126/45  
Улаанбаатар хот

Энэхүү түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул судалгаа, нөөц тогтоох ажил гүйцэтгэх гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г  
Нэг талаас: "Монголын төмөр зам" ТӨХК (цаашид "Захиалагч" гэх), түүнийг төлөөлж Инженер технологийн хэлтсийн дарга Д.Нямлхагва,  
Нөгөө талаас: "Ган ресурс" ХХК (цаашид "Гүйцэтгэгч" гэх), түүнийг төлөөлж "Ган ресурс" ХХК Захирал Б.Хүрэлбаатар (цаашид хамтад нь "Талууд" гэх) нар гэрээнд заасан нөхцлөөр ажил гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулах үүднээс харилцан тохиролцож байгуулав.

### 1. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын 120-р километрээс 240-р километр хүртэлх трассын дагуух 120 километрийн зайнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул судалгаа, нөөцийг тогтоох ажлыг холбогдох стандарт, техникийн нөхцөлийн дагуу хийж гүйцэтгэн Захиалагчид хүлээлгэн өгөх, Захиалагч нь тохиролцсон ажлын хөлсийг төлөхтэй холбоотой үүсэх харилцаанд талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж зохицуулна.

1.2. Энэхүү гэрээ нь энэ гэрээ болон түүний хавсралтуудаас бүрдэнэ. Гэрээ, түүний хавсралтад оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байх бөгөөд гэрээний хамт хүчин төгөлдөр болно.

1.3. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг холбогдох дүрэм, журамд нийцүүлэн Захиалагчаас хүлээлгэн өгсөн батлагдсан ажлын даалгавар, Техникийн нөхцөлийн дагуу хийж гүйцэтгэнэ.

1.4. Талууд Төрийн болон албаны нууцын тухай хуулийг чанад мөрдөн ажиллана.

### 2. Баталгаа

2.1. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу ажил гүйцэтгэх, гэрээнээс үүсэх эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй, энэхүү гэрээг байгуулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, эрхийг эрх бүхий байгууллагаас авсан, тэдгээр нь гэрээний үүргийг зохих ёсоор бүрэн гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр, гэрээнд заагдсан ажлыг гүйцэтгэх боловсон хүчний болон санхүүгийн бүрэн чадамжтай гэдгийг үүгээр баталж байна.

2.2. Гүйцэтгэгч нь зөвлөх инженерийн дүгнэлт гаргуулан ажлын үр дүн болон гүйцэтгэлийн чанарыг баталж байна.

2.3. Гүйцэтгэгч нь ажлыг хууль тогтоомж болон энэ гэрээнд заасан шаардлагад нийцүүлэн, эрхийн болон биет байдлын доголдолгүй, холбогдох бичиг баримт нь үнэн зөв, бүрэн гүйцэд хүлээлгэж өгнө гэдгийг үүгээр баталж байна.

2.4. Талууд энэхүү Гэрээг байгуулахтай холбогдуулан мэдсэн нөгөө талын үйл ажиллагаатай холбоотой нууц мэдээллийг тухайн талын зөвшөөрөлгүйгээр хууль болон энэ гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй, энэхүү гэрээнээс үүссэн харилцаанаас өөр бусад зорилгоор ашиглахгүй байхыг үүгээр баталж байна.

### 3. Хууль тогтоомж, гэрээг тайлбарлах

3.1. Талууд Гэрээг Монгол Улсын хууль тогтоомжид үндэслэн, эрх бүхий байгууллагаас баталсан аливаа дүрэм, журам, заавар, стандарт, шаардлагад нийцүүлэн талуудын хоорондын эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан байгуулав.

3.2. Гэрээний зүйл заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд хэрэв энэ гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хуульд

заасныг баримтална.

#### **4. Гэрээг байгуулсанд тооцох**

4.1. Гэрээнд талуудын төлөөлөх эрхтэй этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

4.2. Гэрээг монгол хэлээр гурван хувь үйлдэх ба Гүйцэтгэгч нэг хувийг, Захиалагч хоёр хувийг тус тус хадгалах бөгөөд хувиуд хууль зүйн адил хүчинтэй байна.

#### **5. Гүйцэтгэх ажил, ажлын гүйцэтгэл**

5.1. Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь өгөгдсөн талбайд Захиалагчийн өгсөн ажлын даалгаврын дагуу түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул судалгаа, нөөцийг тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн гүйцэтгэнэ.

5.2. Ажлын үр дүн нь хууль тогтоомж, дүрэм, заавар, үндэсний болон олон улсын стандартад нийцсэн байх бөгөөд эрх бүхий төрийн байгууллагаар хүлээн зөвшөөрөгдөхүйц байна.

5.3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул судалгаа, нөөцийг тогтоох ажлын тайлан бусад материал нь ажлын үр дүн байна.

5.4. Нөөцийг тогтоохдоо Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэхгүй, зөвлөх инженерийн болон лабораторын дүгнэлтийг харгалзна.

5.5. Ажлын үр дүн болох хайгуул судалгааны ажлын тайлан, түүнд хавсаргасан фото болон схем зураг, диаграм бусад холбогдох дагалдах зүйлс нь захиалагчийн өмчид тооцогдоно.

5.6. Талууд ажлын гүйцэтгэлийн хувь хэмжээ, явц, чанарын талаар харилцан тохиролцож чадаагүй, эсхүл аль нэг талын гаргасан тайлбар, үндэслэл, дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй бол захиалагчийн сонгосон шинжээчээр дүгнэлт гаргуулж, ажлын гүйцэтгэлийг хүлээн авна. Ийнхүү дүгнэлт гаргуулахад гарсан нэмэлт зардлыг ажил гүйцэтгэгч бүрэн хариуцна.

#### **6. Ажил гүйцэтгэх хугацаа**

6.1. Энэхүү гэрээ нь 2019 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлэн 2019 оны 08 дугаар сарын 10-ны өдрийг дуустал хүчинтэй байх ба Гүйцэтгэгч гэрээний хүчинтэй хугацаанд багтааж гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж дууссан байна.

6.2. Давагдашгүй хүчин зүйлээс бусад тухайлбал, ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, ажил гүйцэтгэхэд шаардагдах техник тоног төхөөрөмжийг тээвэрлэхэд гарсан аливаа саатал, эрсдэл, санхүүгийн хүндрэл, энэ гэрээнд заасны дагуу ажлын гүйцэтгэлийн доголдлыг арилгасан зэрэг нь ажил гүйцэтгэх хугацааг зөрчих буюу хойшлуулах үндэслэл болохгүй.

6.3. Ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл хугацаа хожимдуулж гүйцэтгэсэн нь ажил гүйцэтгэгчид захиалагчийн зүгээс энэ гэрээнд заасан алданги болон торгууль ногдуулах үндэслэл болно.

#### **7. Ажлын доголдлыг арилгах, гомдлын шаардлага гаргах**

7.1. Гүйцэтгэгч нь ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, эсхүл захиалагчийн болон төрийн эрх бүхий хяналтын байгууллагын бичгээр өгсөн чиглэл, удирдамжийг зөрчиж гүйцэтгэсэн нь ажлын гүйцэтгэлийг хянах явцад болон энэ гэрээний гомдлын шаардлага гаргах хугацаанд илэрсэн бол уг зөрчлийг өөрийн хөрөнгөөр засаж доголдлыг арилгах, үүнээс үүсэн захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

7.2. Гүйцэтгэгч ажлын үр дүнгийн доголдлын талаар санаатай нуун дарагдуулсан нь хожим илэрвэл тэрээр хариуцлагаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан шууд болон шууд бус хохиролыг бүрэн хариуцна.

7.3. Гүйцэтгэгч гэрээний нөхцөлийг зөрчсөн буюу гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол байвал захиалагч энэ тухай гомдлын шаардлагыг ажил хүлээн авснаас хойш гурван жилийн дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

## 8. Мэдээлэл солилцох, мэдээллээр хангах

### 8.1. Талуудын албан ёсны хаяг:

8.1.1. Захиалагч: "Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компани

Улсын бүртгэлийн дугаар: 9012001025

Регистрийн дугаар: 5214203

Хаяг: Юнион бюлдинг, А блок, 7 давхар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 хороолол, Нарны зам-62, Улаанбаатар /14230/

Утас: 7000-6622, 7010-6655

Имэйл: [info@mtz.mn](mailto:info@mtz.mn)

8.1.2. Гүйцэтгэгч: "Ган ресурс" ХХК

8.1.3. Улсын бүртгэлийн дугаар: 9011650102

Регистрийн дугаар: 6143768

Албан ёсны хаяг: Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, Сити инвестийн 44-р байр, 101 тоот

Утасны дугаар: 7711-9987, 99999987, 88006423

Цахим хаяг: [khurelbaatar.ba@gmail.com](mailto:khurelbaatar.ba@gmail.com)

8.2. Гэрээний талууд үйл ажиллагаа эрхлэн явуулахад шаардлагатай мэдээллийг харилцан солилцож байна.

8.3. Мэдээллийг бичгээр болон факс, и-мэйл зэрэг цахим хэлбэрээр солилцоно.

8.4. Хойшлуулшгүй тохиолдолд талууд мэдээллээ амаар болон утсаар солилцож болох боловч ийнхүү солилцсон мэдээллээ баталгаажуулж 48 цагийн дотор нөгөө талд хүргүүлнэ.

8.5. Захиалагч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдээ баримт, судалгаа, зааварчилгааг ажил гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу боломжит хугацаанд гаргаж өгнө.

## 9. Ажлын хөлс

9.1. Энэхүү гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх ажлын хөлс нь нийт 204,500,000 /хоёр зуун дөрвөн сая таван зуун мянга/ төгрөг /цаашид "ажлын хөлс" гэх/ байна.

9.2. Ажлын хөлсөнд холбогдох НӨАТ болон холбогдох бүх төрлийн татвар, хураамж үндсэн ажлын зардал болон хяналтын зардал, тайланг эрх бүхий байгууллагаар батлуулах зардал, бусад холбогдох зардал багтсан болно.

9.3. Ажил гүйцэтгэх хугацаанд ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн бараа, материал, түлшний үнэ өссөн, Засгийн газраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэн тогтоосон болон Захиалагчаас үл шалтгаалах байдлаар ажлын өртөг нэмэгдэхтэй холбогдсон эрсдэлийг Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

## 10. Төлбөр тооцоо

10.1. Энэхүү гэрээний дагуу гэрээт ажлын хөлс нь 204,500,000 /хоёр зуун дөрвөн сая таван зуун мянга/ төгрөг байна. Энэхүү гэрээний хугацаанд тогтмол байна.

10.2. Ажлын хөлсийг ажлын гүйцэтгэлээр буюу 30 километр эсвэл 60 километр тутамд хийсэн судалгааны ажлын тайлан, зөвлөх инженерийн болон итгэмжлэгдсэн лабораторын дүгнэлтийг ирүүлсэн тухай бүрт гэрээт ажлыг хүлээлцсэн акт, гэрээний дүгнэлтийг үндэслэн ажлын 5 хоногт багтаан төлнө.

10.3. Захиалагч тал төлбөрийг гүйцэтгэгч компанийн ХААН БАНК банкны 5041490080 тоот дансанд шилжүүлнэ.

10.4. Гэрээний үнийн 5 /тав/ хувь болох 10,225,000 /арван сая хоёр зуун хорин таван мянга/ төгрөгийг Гүйцэтгэгч нь ажлын чанарын баталгаа болгон үлдээх ба гэрээт ажлыг Захиалагчид гэрээ дүгнэсэн акт үйлдэн хүлээлгэн өгснөөс хойш 6 сарын хугацаанд Захиалагчийн дансанд барьцаанд үлдээнэ.

## 11. Захиалагчийн эрх, үүрэг

11.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах;

11.2. Ажлын явцын тайланг Гүйцэтгэгчээс авах;

11.3. Гүйцэтгэгч талын гүйцэтгэж буй судалгааны ажил, бусад дагалдах ажилд хяналт тавьж, цаг тухайд нь шалгах, шаардлага тавих;

11.4. Гүйцэтгэгч талын үйл ажиллагааны алдаа, зөрчлүүдийн улмаас үүсэн гарсан аливаа хохирлыг нөхөн төлүүлэх, судалгааны ажлын тайлан, дүгнэлтийн хувьд гарсан бүх алдаа, зөрчлийг үнэ төлбөргүй дахин боловсруулуулах, шинэчлүүлэх талаар шаардлага тавих;

11.5. Шаардлагатай тохилдолд судалгааны ажлын гүйцэтгэлд нарийн мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх эрхтэй.

11.6. Захиалагч нь энэхүү гэрээнд заасны дагуу гэрээний төлбөрийг Гүйцэтгэгчид хугацаанд нь төлөх;

11.7. Судалгааны ажлыг хугацаанд нь гүйцэтгэхэд өөрсдийн зүгээс шаардлагатай туслалцааг Гүйцэтгэгч талд үзүүлэх;

11.8. Захиалагчийн зүгээс судалгааны ажил хийж гүйцэтгэхтэй холбогдсон шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;

11.9. Гүйцэтгэгчийн дансанд судалгааны ажлын хөлсийг гэрээнд заасан хугацаанд шилжүүлэх үүрэгтэй.

11.10. Энэхүү гэрээнд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ,

## **12. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг**

12.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Захиалагчаас шаардах;

12.2. Гэрээнд заасны дагуу гэрээний төлбөрийг хүлээн авах;

12.3. Захиалагч талаас гаргаж өгөх судалгааны ажлын хүрээндэх мэдээ материалыг боломжит цаг хугацаанд нь шаардан авах;

12.4. Захиалагчтай судалгааны ажлын тайлан, дүгнэлт дээр санал зөрөлдсөн тохиолдолд судалгааны ажлын гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт хийлгэх эрхтэй.

12.5. Гэрээнд заасан ажлыг Захиалагчаас өгсөн ажлын даалгаврын дагуу, сүүлийн үеийн баталгаажсан техник, технологийг ашиглан гүйцэтгэн, хүлээлгэн өгөх;

12.6. Судалгааны ажлын үр дүн, тайлан дүгнэлтийг Захиалагчаар хянуулан, баталгаажуулах;

12.7. Судалгааны ажлын үр дүн, тайлан дүгнэлтэд холбогдох дүн шинжилгээг хийлгэн баталгаажуулуулах;

12.8. Судалгааны ажлын үр дүн, тайлан дүгнэлтэд тусгагдсан норматив болон тооцооны үзүүлэлтүүдийн үнэн зөвийг бүрэн хариуцах;

12.9. Судалгааны ажил, тайлан дүгнэлттэй холбогдсон алдаа, зөрчил, Техникийн даалгаврын дагуу гүйцэтгэгдээгүй ажил бий болсон тохиолдолд Захиалагчид дахин үнэ төлбөргүйгээр засч өгөх, хохирлыг барагдуулах;

12.10. Судалгааны ажлыг хэрэгжүүлэх тухай ажлын арга, аргачлал болон гүйцэтгэх хугацааг үе шат тус бүрээр хөтөлбөр боловсруулан Захиалагчид танилцуулах;

12.11. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг хариуцах үүрэгтэй.

12.12. Энэхүү гэрээнд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

## **13. Нууцлал**

13.1. Гэрээ нь Талуудын нууцад хамаарах бөгөөд хууль болон гэрээнд зааснаас бусад тохиолдолд нөгөө Талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээний талаархи аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

13.2. Хуульд заасны дагуу байгууллагын нууцтай танилцах эрх бүхий төрийн байгууллага, түүний албан хаагч энэ зүйлд заасан мэдээлэлтэй танилцахаар хүсэлт гаргасан, эсхүл шаардсан тохиолдолд талууд уг мэдээллийг хуульд заасан журмын дагуу танилцуулах бөгөөд энэ талаар нөгөө талдаа заавал урьдчилан мэдэгднэ.

13.3. Талуудын аль нэг нь энэ зүйлд заасан үүргээ зөрчсөний улмаас нөгөө талын бизнесийн нэр хүндэд ноцтой хохирол учирсан, материаллаг хохирол учруулсан бол буруутай тал нь түүнийг бүрэн хариуцна.

## **14. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах**

14.1. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

14.2. Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нөгөө Талдаа саналаа бичгээр хүргүүлэх бөгөөд тухайн саналд нэмэлт, өөрчлөлтийн үндэслэл, түүний төслийг

тусгана.

14.3. Саналыг хүлээн авсан тал ажлын 10 хоногийн дотор хариу ирүүлэх үүрэгтэй бөгөөд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.

14.4. Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

## **15. Гэрээний зөрчлийг арилгах, гэрээ цуцлах**

15.1. Талууд гэрээний үүргийн зөрчлийг арилгах тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэл хүргүүлэх бөгөөд мэдэгдлийг хүлээн авсан тал гэрээний зөрчлийг 10 хоногийн дотор арилгаж хариу мэдэгдэх үүрэг хүлээнэ.

15.2. Хэрэв зөрчил гаргагч Тал зөрчлийг 10 хоногийн дотор арилгах боломжгүй бол энэ тухай нөгөө Талдаа мэдэгдэх бөгөөд зөрчил арилгах хугацааг Талууд харилцан тохиролцож тогтооно.

15.3. Талууд гэрээг цуцлах саналтай байгаа бол уг саналаа нөгөө Талд бичгээр хүргүүлж, харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

15.4. Захиалагч нь дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

15.4.1. Гүйцэтгэгч энэ гэрээний дагуу ажил гүйцэтгэх хуваарь болон хугацааг 10 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн;

15.4.2. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэхдээ чанарын ноцтой доголдол гаргасан бөгөөд захиалагч ажлыг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй гэж үзсэн;

15.4.3. Гүйцэтгэгч нь ажлын доголдлыг боломжит хугацаанд арилгаагүй, эсхүл ийнхүү арилгахаас зайлсхийсэн;

15.4.4. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.

15.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

15.5.1. Захиалагч төлбөрөө шилжүүлэх хугацааг 10 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн, цаашид боломжит хугацаанд шилжүүлэхгүй нь тодорхой болсон;

15.5.2. Захиалагч ажлын хамрах хүрээг өөрчилсөн нь энэхүү гэрээнд заасан ажлын хөлсийг нэмэгдүүлэх нөхцөл байдлыг бий болгосон бөгөөд захиалагч нэмэлт санхүүжилтийг гаргахаас үндэслэлгүйгээр татгалзсан;

15.5.3. Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.

15.6. Нэг талын санаачилгаар Гэрээг цуцлах тохиолдолд Гэрээ цуцлах тухай мэдэгдлийг 10-аас доошгүй хоногийн өмнө нөгөө талд бичгээр хүргүүлнэ.

15.7. Гэрээг цуцалсан тохиолдолд ийнхүү цуцалснаас хойш ажлын 5 хоногийн дотор гэрээ цуцалсан өдрөөр тасалбар болгон Захиалагч гуравдагч ажил гүйцэтгэгчээр ажлыг гүйцэтгүүлэх эрхтэй. Хэрэв гүйцэтгэгчийн зохих ёсоор гүйцэтгээгүй ажлыг гуравдагч ажил гүйцэтгэгч үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжтой тохиолдолд тухайн ажилд ногдох гүйцэтгэгчийн зардлыг захиалагч төлөх тохиолдолд гуравдагч ажил гүйцэтгэгчтэй зөвшилцсөнийг үндэслэн тооцно.

## **16. Хариуцлага**

16.1. Гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.

16.2. Энэхүү гэрээг захиалагчийн санаачлагаар цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч гэрээний нийт үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний торгууль хүлээх бөгөөд захиалагчид учирсан хохирлыг бүрэн хариуцна.

16.3. Захиалагч нь энэ гэрээнд заасан үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги хүлээнэ.

16.4. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээнд заасны дагуу нэг талын санаачилгаар гэрээг цуцалсан бол буруутай тал нөгөө талд учруулсан аливаа хохирол болон зардлыг нөхөн төлнө.

16.5. Аль нэг тал Гэрээгээр хүлээсэн үүргээ давагдашгүй хүчин зүйлийн улмаас зохих ёсоор биелүүлээгүй болох нь нотлогдвол үүрэг давагдашгүй хүчин зүйлийг арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно. Захиалагч төрийн эрх бүхий байгууллагаас хамааралтайгаар гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд саад учирсан тохиолдолд Захиалагчийн үүрэг тухайн

нөхцөлийг арилах хүртэл хугацаагаар хойшилно.

16.6. Гүйцэтгэгчийн хээрийн лабораторын дүгнэлт шаардлага хангаагүй нь тогтоогдон ажил гүйцэтгэхэд саад учирсан тохиолдолд тухайн ажилд холбогдуулан гаргасан /хайрга, дайрга олборлоход гаргасан гэх мэт/ бүхий л зардлыг Гүйцэтгэгч нь бүрэн хариуцан барагдуулна.

## 17. Давагдашгүй хүчин зүйл

17.1. Дайн, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, террорист халдлага, хүн малын гоц халдварт өвчний улмаас хөл хорио тогтоосон, байгалийн гамшигт үзэгдэл болох үер, хүчтэй шуурга болсон нь талууд үүрэг гүйцэтгэхэд саад учруулж байгаа, эсхүл гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үүргийн гүйцэтгэлийг тухайн нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлуулна.

## 18. Маргаан шийдвэрлэх

18.1. Талууд харилцан хүндэтгэлтэй, бизнесийн ёс зүйг чанд сахиж, гэрээтэй холбоотой аливаа маргаан гарахаас урьдчилан сэргийлж ажиллана.

18.2. Энэхүү гэрээг тайлбарлах болон түүний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрхэмлэнэ.


18.3. Талууд харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

## 19. Гэрээний хавсралт

19.1. Энэхүү гэрээнд дараах хавсралтуудыг хавсаргана. Үүнд:

- |                     |                                                                                       |
|---------------------|---------------------------------------------------------------------------------------|
| 19.1.1. Хавсралт №1 | Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул судалгаа, нөөцийг тогтоох ажлын даалгавар; |
| 19.1.2. Хавсралт №2 | Талуудын хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар                      |

## 20. ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:



Б.ЦЭНГЭЛ



Б.ХҮРЭЛБААТАР



БАТЛАВ  
 "МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК  
 ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


Б. ЦЭНГЭЛ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГ ДАХЬ ЗҮҮНБАЯН  
 ӨРТӨӨНӨӨС ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГТ ОРШИХ  
 ТАВАНТОЛГОЙ НҮҮРСНИЙ ОРД ХҮРТЭЛХ ТӨМӨР ЗАМЫН ТҮГЭЭМЭЛ  
 ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛ, ХАЙРГА ДАЙРГАН МАТЕРИАЛЫН ХАЙГУУЛ  
 СУДАЛГАА НӨӨЦИЙГ ТОГТООХ АЖЛЫН ДААЛГАВАР

1	Судалгаа хийх үндэслэл	
2	Байршил	Өмнөговь аймгийн Цогтцэций сумаас Дорноговь аймгийн Сайншанд сумын нутаг дэвсгэр хүртэл буюу Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын барилгын ажлын талбай
3	Судалгаа хийх газрын хэмжээ	Төмөр замын нийт урт 240 км орчим
4	Судалгааны ажлын хамрах хүрээ	1. Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуу Түгээмэл тархацтай ашигт малтмал, хайрга дайрган материалын хайгуул судалгаа, хайгуул нөөцийг тогтоох.
5	Инженер-геологийн судалгааны ажлын хөтөлбөр боловсруулах	<ul style="list-style-type: none"> <li>• "Монгол орны нутаг дэвсгэрт шугаман байгууламжийн инженер-геологийн судалгаа хийх заавар" БД 11-107-10, "УБ бичих дүрэм" БД 11-107-11 УБ 2011 он</li> <li>• "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНБД 11-07-04 УБ 2004 он</li> <li>• "Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа" БД 11-102-07</li> <li>• "БМЭТЭ-ИЙН нөөц, баялагийг тооцох журам" (УБ 2015 он)</li> </ul>
7	Үндэсний шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>• Судалгааны ажлын явцад захиалагч байгууллагын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран ажиллах</li> </ul>
8	Захиалагч байгууллага	Монголын төмөр зам ТӨХК
9	Инженер-геологи, геотехникийн судалгааны ажлын бүрэлдэхүүн	Хээрийн судалгааны ажил Өрөмдлөгийн судалгаа: <ul style="list-style-type: none"> <li>• Түгээмэл тархацтай ашигт малтмалыг төмөр замын трассын дагуу 5 км тутамд 1 байхаар тооцоолж. 2 цооногийг тус тус 4м гүнтэй чөмөгтэй өрөмдөнө. Нөөцийг 1 карьер 600 000-1 000 000 байхаар тооцоолно.</li> </ul>

39-2  
 Б. ЦЭНГЭЛ  
 16.06.15

		<ul style="list-style-type: none"> <li>• Тухайн карьер дээр 10км тутам байрлаж байгаа карьераас балластын материалын нөөцийг тодорхойлно. Нөөц 200 000-300 000м<sup>3</sup> байна. Хээрийн судалгааны ерөмдлөгийг PQ диаметрээр чөмөгтэй ерөмдөх.</li> <li>• Ул хөрсний дээжлэлтийг ерөмдсөн цооногийн чөмөг болон шруфээс авч чулуулгийн үе давхаргын физик механик шинж чанар, хөрсний нягт, прокторын сайжруулсан нягтруулалт болон Калифорнийн даацын итгэлцүүрийг тодорхойлох туршилтад зориулсан эвдэрсэн, бүтэцтэй дээжийг хөрсний үе тус бүрээс авч нийт ерөмдлөг, малтлагын 60-аас доошгүй хувьд дээжлэлт хийсэн байх.</li> <li>• Ул чулуулгийн дээжлэлтийг ерөмдсөн цооногийн чөмөг болон шруфээс авч чулуулгийн үе давхрагын физик механик шинж чанарыг 50-аас доошгүй хувьд дээжлэлт хийнэ.</li> </ul>
10	Лабораторын туршилт шинжилгээ	<ul style="list-style-type: none"> <li>• Нийт ерөмдлөг, малтлагын 60-с доошгүй хувьд дээжлэлт авч физик шинжилгээ хийсэн байх</li> <li>• Нийт дээжлэлтийн 40 хувьд механик туршилт шинжилгээ хийсэн байх</li> <li>• Карьер тус бүрт чулуулгийн цацрагийн шинжилгээ хийлгэх</li> <li>• Далангийн материалын иж бүрэн шинжилгээ хийх</li> <li>• Хайрга дайрган материалын иж бүрэн шинжилгээ</li> <li>• Балластын материалын цахилгаан шинжилгээ хийлгэх</li> </ul> <p>Материалын шинжилгээн итгэмждэгдсэн лабораторид хийлгэсэн байна.</p>
11	Судалгааны ажлын тайлан боловсруулах	<ul style="list-style-type: none"> <li>• Судалгааны ажлын тайлан, зураг графикийн тайлбар бичиг, тайлан дүгнэлтийг бичих.</li> <li>• Төмөр замын ашиглалтын явцад байгаль орчны өөрчлөлтийг хянах, хяналтын системийн бүтэц, нэгдсэн мэдээллийн сангийн ажиллах зарчим, загварыг боловсруулах</li> <li>• Өрөмдлөг, шруфын нөхөн сэргээлтийг хийж булсан байна</li> </ul>



		<ul style="list-style-type: none"> <li>• Судалгаа шинжилгээний байгуулгууд нь орон нутгийн засаг захиргааны байгууллагуудад заавал мэдэгдэнэ</li> </ul>
--	--	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Тайлбар: 2019 оны 05 сарын 22 өдрийн Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн дарга С.Батболдоор батлуулсан инженер-геологийн ажлын даалгаварт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын судалгааны ажил ороогүй байсан учраас нэмэлтээр орууллаа.

Хянасан:

"МТЗ" ТӨХК-ийн Дэд захирал  
"МТЗ" ТӨХК-ийн Инженер, технологийн хэлтсийн дарга



Р.Батсүх

Д.Нямлхагва

Боловсруулсан:

"МТЗ" ТӨХК-ийн материалын инженер



С.Одонунгалаг

--oOo--

29-2

15 06 2019

